

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны .....дугаар  
сарын ....-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/6 дугаар зүйлийн 6.6.3 дахь заалт:

“6.6.3.бооцоот таавар, хонжворт сугалааны бооцоо, хонжворыг цуглуулдаг, дамжуулдаг, шилжүүлдэг.”

2/13 дугаар зүйлийн 13.2.13, 13.2.14 дахь заалт:

“13.2.13.Хөдөлмөрийн тухай хуулийн 73 дугаар зүйлд заасны дагуу ажилчныг сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэхтэй холбоотой гарсан зардлыг хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байгаа нийт ажилчдад өмнөх дараалсан 12 сард олгосон цалингийн зардлын нийт дүнгийн 10 хувиас хэтрэхгүй байна. Үүнд албан татвар төлөгчийн эрх бүхий албан тушаалтантай Татварын ерөнхий хуулийн 27.1.1-д заасан харилцан хамаарал бүхий ажилтан хамаарахгүй;

13.2.14.Албан татвар төлөгчийн эрхэлж байгаа аж ахуйн үйл ажиллагаатай шууд холбоогүй, хангамжийн зардлаас бусад, ажилчдын хувийн хэрэгцээнд зориулан худалдаж авсан бараа, ажил, үйлчилгээний зардлыг хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байгаа нийт ажилчдад өмнөх дараалсан 12 сард олгосон цалингийн зардлын нийт дүнгийн 5 хувиас хэтрэхгүй байна. Үүнд албан татвар төлөгчийн эрх бүхий албан тушаалтантай Татварын ерөнхий хуулийн 27.1.1-д заасан харилцан хамаарал бүхий ажилтан хамаарахгүй.”

3/13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсэг:

“13.6.Албан татвар төлөгчийн гадаад улсын нутаг дэвсгэрт оршин суугч бус этгээдээс авсан ажил, үйлчилгээ болон Монгол Улсад импортлохоос бусад худалдан авсан барааны зардлыг бэлэн бусаар төлсөн баримт, холбогдох гэрээг үндэслэн энэ хуулийн 13.1.4-т заасан төлбөрийн баримт шаардахгүйгээр албан татвар ногдох орлогоос хасаж тооцно.

4/20 дугаар зүйлийн 20.2.10 дахь заалт:

“20.2.10.энэ хуулийн 20.2.4-т заасныг үл харгалзан албан татвар төлөгчийн хувьцаа, хувь оролцооны 50 ба түүнээс дээш хувийг эзэмшдэг Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчид тухайн албан татвар төлөгчөөс олгосон ногдол ашгийн орлогод 15 хувиар.”

5/20 дугаар зүйлийн 20.4, 20.5 дахь хэсэг:

“20.4.Энэ хуулийн 20.1.2-т заасан нэмж ногдуулах албан татварын хувийг Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, хотын Зөвлөл тогтооно.

20.5.Энэ хуулийн 20.4-т заасны дагуу тухайн татварын жилд мөрдөх албан татварын хувийг өмнөх татварын жилийн 3 дугаар улиралд багтаан тогтоох бөгөөд үүнийг татварын дараалсан хоёр жилийн хугацаанд өөрчлөхгүй тогтвортой хадгална.”

6/21 дүгээр зүйлийн 21.1.17, 21.1.18 дахь заалт:

“21.1.17.Гамшгийн тухай хуульд заасан гамшиг, аюулт үзэгдэл, ослын улмаас үүссэн хохирлын даатгалын нөхөн төлбөр;

21.1.18.Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн өөрийн 100 хувь эзэмшдэг аж ахуйн нэгжээс авсан ногдол ашиг.”

7/30 дугаар зүйлийн 30.15 дахь хэсэг:

“30.15.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нэмж хувьцаа гаргаж хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор эцсийн эзэмшигчийн хувь оролцоо, саналын эрхийн бүтэц өөрчлөгдсөн тохиолдолд эрх шилжүүлсэн гэж үзэхгүй.”

**2 дугаар зүйл.**Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 дэх заалтын “18.6.6” гэсний өмнө “18.6.5,” гэж, 22 дугаар зүйлийн 22.9.4 дэх заалтын “цэцэрлэгжүүлэх,” гэсний дараа “олон нийтэд үйлчлэх зориулалт бүхий ариун цэврийн байгууламж шинээр байгуулах болон засварлах, хяналтын камер суурилуулах,” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг:

“20.1.Энэ хуулийн 18.2, 18.3, 18.5-д заасны дагуу тодорхойлсон тухайн жилийн орлогод доор дурдсаны дагуу албан татвар ногдуулна:

20.1.1.Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, доор дурдсанаас бусад салбарт үйл ажиллагаа явуулдаг 2.5 тэрбум төгрөг хүртэлх татвар ногдох орлоготой албан татвар төлөгчийн албан татвар ногдуулах орлогод 10 хувиар:

20.1.1.а.ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул хийх, олборлох, ашиглах, тээвэрлэх, борлуулах;

20.1.1.б.согтууруулах ундаа, тамхины ургамал тарих, тамхи үйлдвэрлэх, импортлох;

20.1.1.в.газрын тосны бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, бүх төрлийн шатахууныг импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх, газрын тос хайх, олборлох, борлуулах.

20.1.2.энэ хуулийн 20.1.1-д зааснаас бусад албан татвар төлөгчид доор дурдсан хувиар албан татвар ногдуулна:

| Албан татвар ногдуулах орлого                           | Суурь хувь | Нэмж ногдуулах хувь |
|---------------------------------------------------------|------------|---------------------|
| 6 тэрбум төгрөг хүртэлх                                 | 6          | 0-4                 |
| 6 тэрбум төгрөгөөс дээш давсан 10 тэрбум төгрөг хүртэлх | 9          | 0-6                 |
| 10 тэрбум төгрөгөөс дээш                                | 15         | 0-10                |

”

2/22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг:

“22.1.Энэ хуулийн 20.1.1-д заасны дагуу тодорхойлж, жилийн эцсийн татварын тайлангаар ногдуулж, төлсөн албан татварыг 90 хувиар хөнгөлнө.”

**4 дүгээр зүйл.** Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 дахь заалтын “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 11.5, 18 дугаар зүйлд” гэснийг “Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлд” гэж, 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтын “18.6.5-д” гэснийг “18.4-т” гэж, мөн зүйлийн 20.3 дахь заалтын “хувь, хэмжээгээр” гэснийг “хувиар” гэж, 21 дүгээр зүйлийн 21.1.9 дэх заалтын “Боловсролын тухай хуулийн 12.1,” гэснийг “Боловсролын ерөнхий хуулийн 18.1,” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “20-ны” гэснийг “сүүлийн өдрийн” гэж, 25 дугаар зүйлийн 25.2, 26 дугаар зүйлийн 26.1, 26.2, 26.8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.12 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.8, 31.9 дэх хэсгийн “02 дугаар сарын 10-ны” гэснийг “03 дугаар сарын 01-ний” гэж, 26 дугаар зүйлийн 26.2, 30 дугаар зүйлийн 30.12 дахь хэсгийн “07 дугаар сарын 20-ны” гэснийг “08 дугаар сарын 01-ний” гэж, 27 дугаар зүйлийн 27.11 дэх хэсгийн “тухайн татварын жилийн дунджаар тооцож, дараагийн татварын жилийн 01 дүгээр сард багтаан” гэснийг “албан ханшаар Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын зөвлөмжийн дагуу тооцож” гэж, 30 дугаар зүйлийн 30.10 дахь

хэсгийн “хувь хэмжээгээр” гэснийг “хувиар” гэж, 31 дүгээр зүйлийн 31.6 дахь хэсгийн “хувь хэмжээг” гэснийг “хувийг” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.** Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.12 дахь заалтын “энэ хуулийн 22.9-д зааснаас бусад” гэснийг, 17 дугаар зүйлийн 17.11 дэх хэсгийн “тухайн улиралд” гэснийг, Тавдугаар бүлгийн гарчгийн “, ХЭМЖЭЭ” гэснийг, 20 дугаар зүйлийн гарчгийн “, хэмжээ” гэснийг, 22 дугаар зүйлийн 22.3, 22.4 дэх хэсгийн “20.2.7,” гэснийг, мөн зүйлийн 22.10 дахь хэсгийн “, 22.5.9” гэснийг, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн “Энэ хуулийн 25.1-д заасан урьдчилан тодорхойлсон хуваарийн дагуу” гэснийг, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийн “энэ хуулийн 29.1-д заасны дагуу татварын албанд бүртгүүлээгүй” гэснийг тус тус хассугай.

**6 дугаар зүйл.** Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.7, 15.8 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.2.7 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.5.1, 22.5.9 дэх заалт, мөн зүйлийн 22.8 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 23.9 дэх хэсэг, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**7 дугаар зүйл.** Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөнө.

Гарын үсэг